



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 4/814

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /сав, иргэний амрах зориулалттай сандал/ тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Даваасүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга

Нарийн бичгийн дарга: Б.Пүрэвсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын бараа, зөвлөх үйлчилгээ худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: 3.Нацагням -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

В.Ганцэцэг -Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ахлах ажилтан
Ш.Авирамд -Бүтээлч хөгжлийн хөтөч ТББ-ын гишүүн (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Б.Даваасүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

0111011141